ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Булган сумын 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/069/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn<br>Өмнөговь аймаг<br><br>2026 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn<br>Аудитор: П.Санчиргарав<br>Утас: 70533552 Цахим хаяг: Sanchirgaravp@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....... 4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....... 5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан. ....... 6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ....... 8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....... 8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....... 8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ....... 8
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл ....... 9
3.5.1 Төсвийн төлөвлөлт ....... 9
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ....... 9
4. АУДИТЫН ТАЙЛАН ....... 11
4.1 Ерөнхий зүйл ....... 11
4.2 Материаллаг байдал ....... 11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....... 11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....... 11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ....... 12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 12
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ....... 12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....... 12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....... 12
5.1 Төлбөрийн акт ....... 12
5.1 Албан шаардлага ....... 12
5.2 Зөвлөмж ....... 12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ....... 13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539. Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 171

танай ______________-ны №______________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН 5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ А.БОЛОРМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 2,905.0 мянган төгрөгийн бараа материал, 60,680.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нийлүүлснийг бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 44,823.6 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 57,705.5 мянган төгрөгийн нутгийн дэмийн урамшуулал, 12,159.7 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нэмэгдэл, 76,095.5 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний

46260:00257

хэрэгжилтийг 79.8 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 96,983,000.77 | 121,966,207.84 |
| **31** | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 60,730,049.58 | 20,116,756.84 |
| **312** | Банкинд байгаа бэлэн мөнгө | 60,730,049.58 | 20,116,756.84 |
| **3121** | Төгрөг | 60,730,049.58 | 20,116,756.84 |
| **31211** | Төрийн сангийн харилцах | 60,730,049.58 | 20,116,756.84 |
| **33** | АВЛАГА | 82,500.19 | - |
| **33100** | Ажиллагчидтай холбогдсон авлага | 82,500.19 | - |
| **35** | БАРАА МАТЕРИАЛ | 36,170,451.00 | 101,849,451.00 |
| **354** | Хангамжийн материал | 36,170,451.00 | 101,849,451.00 |
| **35420** | Аж ахуйн материал | 7,547,300.00 | 26,547,300.00 |
| **35460** | Хүнсний материал | 1,321,000.00 | - |
| **35470** | Бусад хангамжийн материал | 27,302,151.00 | 75,302,151.00 |
| **2** | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 609,770,112.60 | 617,196,760.04 |
| **39** | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 609,770,112.60 | 617,196,760.04 |
| **392** | Биет хөрөнгө | 598,722,112.60 | 606,148,760.04 |
| **39201** | Барилга, байгууламж, орон сууц | 481,732,251.00 | 481,732,251.00 |
| **39202** | Хуримтлагдсан элэгдэл | (39,274,754.04) | (47,303,624.88) |
| **39205** | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 87,713,377.00 | 94,793,377.00 |
| **39206** | Хуримтлагдсан элэгдэл | (16,799,301.76) | (34,060,802.08) |
| **39207** | Тавилга, аж ахуйн эд хогшил | 90,857,667.00 | 92,057,667.00 |
| **39208** | Хуримтлагдсан элэгдэл | (21,413,938.48) | (40,315,195.88) |
| **39214** | Бусад үндсэн хөрөнгө | 46,825,801.00 | 97,385,401.00 |
| **39215** | Хуримтлагдсан элэгдэл | (31,795,039.12) | (39,016,363.12) |
| **39217** | Ном | 876,050.00 | 876,050.00 |
| **393** | Биет бус хөрөнгө | 11,048,000.00 | 11,048,000.00 |
| **39303** | Бусад биет бус хөрөнгө | 11,048,000.00 | 11,048,000.00 |
| **3** | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 706,753,113.37 | 739,162,967.88 |
| **4** | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 7,265,833.83 |
| **41** | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 7,265,833.83 |
| **413** | Өглөг | - | 7,265,833.83 |
| **41310** | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 7,265,833.83 |
| **5** | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 333,498,495.37 | 358,642,516.05 |
| **51** | Засгийн газрын хувь оролцоо | 333,498,495.37 | 358,642,516.05 |
| **512** | Хуримтлагдсан үр дүн | 319,134,187.71 | 344,278,208.39 |
| **51210** | Өмнөх үеийн үр дүн | 319,134,187.71 | 319,134,187.71 |
| **51220** | Тайлант үеийн үр дүн | - | 25,144,020.68 |
| **51300** | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 14,364,307.66 | 14,364,307.66 |
| **6** | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 333,498,495.37 | 365,908,349.88 |
| **1** | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 96,983,000.77 | 121,966,207.84 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 626,695,539.57 | 737,876,431.00 |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 212,734.139.57 | 239.328.431.00 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 212,734.139.57 | 239.328.431.00 |
| **120004** | Төсөв байгууллагын өөрийн орлого | 85,688,805.57 | 114,688,831.00 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 85,688,805.57 | 114,688,831.00 |
| **120017** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 122,645,334.00 | 57,639,600.00 |
| **120018** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 4,400,000.00 | 67,000,000.00 |
| **13** | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 413,961,400.00 | 498,548,000.00 |
| **1310** | Улсын төвлөрсөн төсвөөс | 349,359,200.00 | 422,452,500.00 |
| **131001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 349,359,200.00 | 422,452,500.00 |
| **1320** | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 64,602,200.00 | 76,095,500.00 |
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 64,602,200.00 | 76,095,500.00 |
| **2** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 561,060,655.62 | 712,732,410.32 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 561,060,655.62 | 712,732,410.32 |

|  |  |  |  |
|---|---|---|---|
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 547,474,378.10 | 709,912,978.38 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 330,860,367.55 | 475,729,875.38 |
| **210101** | Үндсэн цалин | 210,844,986.72 | 262,471,355.78 |
| **210102** | Нэмэгдэл | 109,372,130.83 | 181,468,835.36 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | - | 11,105,000.00 |
| **210104** | Урамшуулал | 10,643,250.00 | 20,684,684.24 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 41,359,394.84 | 56,398,622.38 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 28,390,051.82 | 38,052,463.72 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 3,265,816.14 | 4,471,244.08 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 1,632,908.26 | 2,260,072.03 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 1,589,947.88 | 2,260,114.11 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 6,480,670.74 | 9,354,728.44 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 59,089,649.48 | 62,779,368.06 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 4,635,524.48 | 5,969,243.06 |
| **210302** | Түлш, халаалт | 51,638,125.00 | 52,352,125.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 2,816,000.00 | 4,458,000.00 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 16,502,160.00 | 4,323,140.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 192,600.00 | 200,000.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 2,562,760.00 | 1,715,240.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 11,000.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 576,600.00 | 150,000.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,170,200.00 | 2,246,900.00 |
| **2105** | Нормативт зардал | 42,967,990.00 | 41,644,120.00 |
| **210502** | Хоол, хүнс | 42,967,990.00 | 41,644,120.00 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,999,000.00 | 10,496,700.00 |
| **210604** | Урсгал засвар | 3,999,000.00 | 10,496,700.00 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,287,800.00 | 1,877,200.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,287,800.00 | 1,877,200.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,408,016.23 | 56,663,952.56 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,115,888.00 | 1,706,000.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,712,250.00 | 3,545,000.00 |
| **210903** | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 44,579,878.23 | 51,412,952.56 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,586,277.52 | 2,819,431.94 |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | 12,072,727.00 | - |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,072,727.00 | - |
| **2134** | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,513,550.52 | 2,819,431.94 |
| **213403** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,513,550.52 | 2,819,431.94 |
| **3** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (61,410,450.05) | 25,144,020.68 |
| **5** | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (61,410,450.05) | 25,144,020.68 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **499,650,205.57** | **613,236,831.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **85,688,805.57** | **114,688,831.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 85,688,805.57 | 114,688,831.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 85,688,805.57 | 114,688,831.00 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 85,688,805.57 | 114,688,831.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **413,961,400.00** | **498,548,000.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 349,359,200.00 | 422,452,500.00 |
| **131001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 349,359,200.00 | 422,452,500.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 64,602,200.00 | 76,095,500.00 |
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 64,602,200.00 | 76,095,500.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **505,683,627.58** | **652,650,123.74** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **505,683,627.58** | **652,650,123.74** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **492,097,350.06** | **649,830,691.80** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 330,860,367.55 | 468,464,041.55 |
| **210101** | Үндсэн цалин | 210,844,986.82 | 255,205,521.95 |
| **210102** | Нэмэгдэл | 109,372,130.73 | 181,468,835.36 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | - | 11,105,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **210104** | Урамшуулал | 10,643,250.00 | 20,684,684.24 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,441,895.03 | 56,316,122.19 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 28,419,752.01 | 37,969,963.53 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 3,279,016.14 | 4,471,244.08 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 1,639,508.26 | 2,260,072.03 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 1,596,547.88 | 2,260,114.11 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 6,507,070.74 | 9,354,728.44 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 59,089,649.48 | 62,779,368.06 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 4,635,524.48 | 5,969,243.06 |
| **210302** | Түлш, халаалт | 51,638,125.00 | 52,352,125.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 2,816,000.00 | 4,458,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 43,234,228.00 | 40,323,120.00 |
| **210502** | Хоол, хүнс | 43,234,228.00 | 40,323,120.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,999,000.00 | 10,496,700.00 |
| **210604** | Урсгал засвар | 3,999,000.00 | 10,496,700.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,287,800.00 | 1,877,200.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,287,800.00 | 1,877,200.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,184,410.00 | 9,574,140.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,336,060.00 | 6,029,140.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,848,350.00 | 3,545,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,586,277.52** | **2,819,431.94** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,072,727.00 | - |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,072,727.00 | - |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,513,550.52 | 2,819,431.94 |
| **213403** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,513,550.52 | 2,819,431.94 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(6,033,422.01)** | **(39,413,292.74)** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **1,200,000.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **1,200,000.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | - | 1,200,000.00 |
| **223001** | Бусад хөрөнгө | - | 1,200,000.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(1,200,000.00)** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (6,033,422.01) | (40,613,292.74) |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 60,730,049.58 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 60,730,049.58 | 20,116,756.84 |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **499,650,205.57** | **613,236,831.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **85,688,805.57** | **114,688,831.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 373,254,618.00 | 14,364,307.66 | 257,763,367.99 | 645,382,293.65 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 373,254,618.00 | 14,364,307.66 | 257,763,367.99 | 645,382,293.65 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 61,370,819.72 | 61,370,819.72 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 373,254,618.00 | 14,364,307.66 | 319,134,187.71 | 706,753,113.37 |
| 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 373,254,618.00 | 14,364,307.66 | 319,134,187.71 | 706,753,113.37 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 373,254,618.00 | 14,364,307.66 | 319,134,187.71 | 706,753,113.37 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 25,144,020.68 | 25,144,020.68 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 373,254,618.00 | 14,364,307.66 | 344,278,208.39 | 731,897,134.05 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| | **Үзүүлэлт** | **Тайлант оны** |
|---|---|---|

| Эдийн засгийн ангилал | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 723,347,700.0 | 651,030,691.80 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 723,347,700.0 | 651,030,691.80 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 723,347,700.0 | 651,030,691.80 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 505,127,800.0 | 468,464,041.55 |
| **210101** | Үндсэн цалин | 296,737,700.0 | 255,205,521.95 |
| **210102** | Нэмэгдэл | 202,577,300.0 | 181,468,835.36 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | - | 11,105,000.00 |
| **210104** | Урамшуулал | 5,812,800.00 | 20,684,684.24 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 62,888,000.0 | 56,316,122.19 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 42,682,900.00 | 37,969,963.53 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 5,051,300.0 | 4,471,244.08 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 2,525,600.0 | 2,260,072.03 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 2,525,600.0 | 2,260,114.11 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 10,102,600.0 | 9,354,728.44 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 82,293,600.0 | 62,779,368.06 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 7,132,800.0 | 5,969,243.06 |
| **210302** | Түлш, халаалт | 69,342,600.0 | 52,352,125.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 5,818,200.0 | 4,458,000.00 |
| **2105** | Нормативт зардал | 48,192,800.0 | 40,323,120.00 |
| **210502** | Хоол, хүнс | 48,192,800.0 | 40,323,120.00 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,500,000.0 | 10,496,700.00 |
| **210604** | Урсгал засвар | 10,500,000.0 | 10,496,700.00 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,072,300.0 | 1,877,200.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,072,300.0 | 1,877,200.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,273,200.0 | 10,774,140.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,727,600.0 | 7,229,140.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,545,600.0 | 3,545,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 723,347,700.0 | 610,417,399.06 |
| **1310** | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 424,671,500.0 | 422,452,500.00 |
| **131001** | Улсын төсвөөс санхүүжих | 424,671,500.0 | 422,452,500.00 |
| **1320** | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 92,793,600.0 | 73,276,068.06 |
| **132001** | Орон нутгийн төсвөөс | 92,793,600.0 | 73,276,068.06 |
| **120004** | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 205,882,600.0 | 114,688,831.00 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 149,225,000.0 | 114,688,831.00 |
| **1200043** | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 56,657,600.0 | - |
| **4** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 60,730,049.58 |
| **5** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **-** | 20,116,756.84 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Булган сумын 5 дугаар цэцэрлэг нь 2025-2026 оны хичээлийн жилд үйл ажиллагааны зорилгоо “Сургуулийн өмнөх боловсролын эзэмших чадамжийг хөгжүүлэхэд хамтын ажиллагааг хангаж сургалт үйл ажиллагааны чанар үр дүнг сайжруулах” гэж тодорхойлсон байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудыг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль,
- Төрийн албаны тухай хууль,
- Төсвийн тухай хууль,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Булган сумын 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэх талаар өөрчлөлт

оруулах шаардлагатай. 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,409.85 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 60,730.05 | 20,116.75 | (40,613.30) |
| Авлага | 82.50 | - | (82.50) |
| Бараа материал | 36,170.45 | 101,849.45 | 65,679.00 |
| Үндсэн хөрөнгө | 609,770.11 | 617,196.76 | 7,426.65 |
| **Нийт хөрөнгө** | **706,753.11** | **739,162.96** | **32,409.85** |
| Дансны өглөг | - | 7,265.83 | 7,265.83 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 706,753.11 | 731,897.13 | 25,144.02 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **706,753.11** | **739,162.96** | **(12,441.79)** |

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд :

- Мөнгөн хөрөнгийг 20,116.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.
- Бараа материалын үлдэгдэл 101,849.5 мянган төгрөг болж өмнөх оноос 65,679.0 мянган төгрөгөөр өсөхөд үнэ төлбөр хүлээн авсан бараа материалын үлдэгдэл нөлөөлсөн байна
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь 617,196.8 мянган төгрөг болж өмнөх оноос 7,426.7 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаж ажилласан байна.

Тус байгууллага нь “Си Ти эс” ХХК-ийн санхүүгийн программыг 2020 оноос эхлэн ашиглаж эхэлсэн бөгөөд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нийцэж байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 424,671.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 92,793.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 149,225.0 мянган төгрөг, нийт зарлагыг 723,347.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 зорилт, 40 арга хэмжээг санхүүжүүлэхээр 424,671.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 422,452.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 73,276.1 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 114,688.8 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардал 651,030.7 мянган төгрөг буюу 92.2 хувийн гүйцэтгэл байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг 36,663.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 6,571.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 19,514.2 мянган төгрөг, нормативт зардлыг 7,869.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 195.1 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 1,499.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 80233 | Хүүхэд хамгаалал | 1,040,500.0 | 969,000.0 | 71,500.0 | 93.1% |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 942,300.0 | 550,000.0 | 392,300.0 | 58.4% |
| 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 45,131,100.0 | 44,704,510.0 | 426,590.0 | 99.1% |
| 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 1,565,400.0 | 1,565,400.0 | - | 100.0% |
| 81823 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 831,900.0 | 831,900.0 | - | 100.0% |
| 81832 | Нүүдлийн бүлэгт хамруулах | 5,721,100.0 | 4,711,200.0 | 1,009,900.0 | 82.3% |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын | 548,677,700.0 | 535,456,865.4 | 13,220,834.6 | 97.6% |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 14,259,700.0 | 12,735,250.0 | 1,524,450.1 | 89.3% |
| 83602 | ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан | 186,041,500.0 | 151,520,633.5 | 34,520,866.5 | 81.4% |
| 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 52,386,200.0 | 37,447,589.3 | 14,938,610.7 | 71.5% |
| | **ДҮН** | **856,597,400.0** | **790,492,348.2** | **66,105,051.8** | 92.3% |

- Тус байгууллага нь 13 орон тоотой ажиллахаас гүйцэтгэлээр 13 орон тоотой ажилласан байна.
- Тайлант онд Боловсролын сайдын 2025 оны 1/554 албан бичгийн дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт заалт оруулан өдөрт 5,000 төгрөгөөр тооцон 11,105.0 мянган төгрөгийг төсөвлөн гүйцэтгэлээр 100 хувь зарцуулсан байна.
- Гадаад томилолт, арга хэмжээний зардал байхгүй байна.
- Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх сургалтад 6 албан хаагчыг хамруулж, 720.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний зардал гараагүй байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Булган сумын 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Санчиргарав гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Болормаа, аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Булган сумын 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “**Дунд”** гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 561,061.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,610.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Материаллаг байдал сонгосон суурь үзүүлэлт нь өмнөх оны үзүүлэлтээс өссөн тул шинэчлэн тогтоосон. Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг нийт зардлын 70 хувиар буюу 3,972.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллагад хамаарал бүхий 29 заалтуудын хүрээнд нягтлан шалгахад хориглосон зардлыг санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил гараагүй болно.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудит хийгдээгүй байна.

**4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал хандуулахуйц анхаарч үзэх асуудал байхгүй гэж үзлээ.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар алдаа[1] илрээгүй байна.

Аудитаар  зөрчил илрээгүй байна.

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогүй

**5.1 Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй байна.

**5.2 Зөвлөмж**

Зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *Залруулсан* | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |